

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Аудитын код: САГ-2021/21/СТА-ТТЗ.....	0
1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4 Материаллаг байдал.	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	17
3.7 Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	18
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	20
4. Менежментийн захидал.....	21
4.1. Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал.....	21
4.2. Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал.....	21
4.3 Урьдчилж гарсан зардалтай холбоотой асуудал	22
4.4 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал.....	22
4.5 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал.....	22
4.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
УЛСЫН ХОРООНЫ ДАРГА
Ц.ШАРАВЖАМЦ ТАНАА

2021.03.25 № 01/1009
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Биеийн тамир, спортын улсын хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус хорооны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 94 хувь гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 330.6 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн нь бидний тооцсон материаллаг байдлаас давсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд

хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, эрх ба үүрэг, бодитой оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		93,668,154.4
31	Мөнгөн хөрөнгө		2,039,704.6
33	Авлага		3,403,731.9
34	Урьдчилгаа		9,489,977.9
35	Бараа материал		1,132,835.0
36	Нөөцийн бараа		77,601,904.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		51,949,236.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		51,949,236.1
392	Биет хөрөнгө		51,104,826.9
393	Биет бус хөрөнгө		844,409.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		145,617,390.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,838,195.9
41	Богино хугацаат өр төлбөр		1,838,195.9
413	Өглөг		1,786,245.9
414	Урьдчилж орсон орлого		51,950.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		143,779,194.6
51	Засгийн газрын хувь оролцоо		143,779,194.6
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		32,881,920.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,284,813.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		31,597,107.5
512	Хуримтлагдсан үр дүн		82,521,317.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		28,375,956.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		145,617,390.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		56,735,729.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		15,540,538.0
120	Нийтлэг татварын бус орлого		15,540,538.0
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		41,195,191.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		20,282,665.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		20,282,665.2
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		15,961,007.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,082,336.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		392,941.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		231,091.1
2104	Хангамж бараа материалын зардал		88,093.4
2105	Нормативт зардал		49,957.2
2106	Эд хогшил урсгал засварын зардал		45,133.6
2107	Томилолт зочны зардал		7,283.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		9,305,358.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,758,811.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,321,657.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		36,453,064.4
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		11,409,131.8
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-11,409,131.8
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		25,043,932.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		45,895,464.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,700,272.6
120	Нийтлэг татварын бус орлого		4,700,272.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		41,195,191.6
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		30,808,923.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		30,808,923.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		16,889,309.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,310,470.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		421,510.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		338,598.4
2104	Хангамж, бараа материалын зардал		134,289.8
2105	Нормативт зардал		43,835.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,372,131.4
2107	Томилолт, зочны зардал		6,021.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		9,077,765.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,184,687.5
211	ХҮҮ		-
212	ТАТААС		9,598,912.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,320,701.6
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		15,086,540.7
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		60,245.0
	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт		60,245.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		13,062,938.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		13,062,938.1
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-13,002,693.1
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-44,143.0
	Бусад эх үүсвэр		3,500.0
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		47,643.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		2,039,704.6

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,039,704.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	118,735,262.0	-	118,735,262.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,735,262.0	-	118,735,262.0
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	25,043,932.6	-	25,043,932.6
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	143,779,194.6		143,779,194.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,350,860,400.00	50,635,150,784.39	8,715,709,615.60	85.3
2	УРСГАЛ ЗАРДАЛ	28,496,660,400.00	26,685,692,926.69	1,810,967,473.30	93.6
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,021,325,700.00	14,255,938,016.69	1,765,387,683.30	89.0
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,012,500,600.00	2,855,133,115.00	157,367,485.00	94.8
5	Үндсэн цалин	584,621,600.00	566,701,512.00	17,920,088.00	96.9
6	Нэмэгдэл	146,772,400.00	97,424,167.00	49,348,233.00	66.4
7	Унаа хоолны хөнгөлөлт	32,415,000.00	15,785,000.00	16,630,000.00	48.7
8	Урамшуулал	2,248,691,600.00	2,175,222,436.00	73,469,164.00	96.7
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	383,496,300.00	351,467,092.00	32,029,208.00	91.6
10	Тэтгэврийн даатгал	317,069,100.00	303,975,892.00	13,093,208.00	95.9

11	Тэтгэмжийн даатгал	16,606,900.00	11,872,500.00	4,734,400.00	71.5
12	ҮОМШӨ-ний даатгал	13,285,400.00	9,498,500.00	3,786,900.00	71.5
13	Ажилгүйдлийн даатгал	3,321,300.00	2,374,600.00	946,700.00	71.5
14	Эрүүл мэндийн даатгал	33,213,600.00	23,745,600.00	9,468,000.00	71.5
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,896,800.00	157,732,600.75	68,164,199.20	69.8
16	Гэрэл, цахилгаан	94,266,600.00	52,910,840.00	41,355,760.00	56.1
17	Түлш, халаалт	107,177,200.00	76,103,569.57	31,073,630.40	71.0
18	Цэвэр, бохир ус	24,453,000.00	28,718,191.18	-4,265,191.20	117.4
19	Хангамж, бараа материалын зардал	38,260,400.00	37,408,420.75	851,979.20	97.8
20	Бичиг хэрэг	4,139,000.00	5,410,560.00	-1,271,560.00	130.7
21	Тээвэр, шатахуун	6,370,000.00	6,370,000.00	0	100.0
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,102,600.00	5,680,750.75	421,849.20	93.1
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,323,200.00	4,020,000.00	1,303,200.00	75.5
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,325,600.00	15,927,110.00	398,490.00	97.6
25	Нормативт зардал	10,635,000.00	10,631,500.00	3,500.00	100.0
26	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,635,000.00	10,631,500.00	3,500.00	100.0
27	Эд хогшил, урсгал засварын зардал	1,627,420,500.00	1,393,772,793.00	233,647,707.00	85.6
28	Багаж, техник, хэрэгсэл	374,500,000.00	307,515,683.00	66,984,317.00	82.1
29	Урсгал засвар	1,252,920,500.00	1,086,257,110.00	166,663,390.00	86.7
30	Томилолт, зочны зардал	1,640,000.00	1,640,000.00	0	100.0
31	Дотоод албан томилолт	1,640,000.00	1,640,000.00	0	100.0
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,930,860,400.00	8,796,728,175.19	1,134,132,224.80	88.6
33	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,920,830,400.00	8,788,816,548.19	1,132,013,851.80	88.6
34	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	4,200,000.00	800,000.00	84.0
35	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00	0	100.0
36	Тээврийн хэрэгслийн татвар	800,000.00	381,475.00	418,525.00	47.7
37	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	122,000.00	178,000.00	40.7
38	Газрын төлбөр	2,930,000.00	2,208,152.00	721,848.00	75.4
39	Бараа үйлчилгээний бусад зардал	790,615,700.00	651,424,320.00	139,191,380.00	82.4

40	Бараа үйлчилгээний бусад зардал	771,843,500.00	637,943,720.00	133,899,780.00	82.7
41	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,772,200.00	13,480,600.00	5,291,600.00	71.8
42	ТАТААС	9,600,000,000.00	9,598,912,100.00	1,087,900.00	99.9
43	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	9,600,000,000.00	9,598,912,100.00	1,087,900.00	99.9
44	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	9,600,000,000.00	9,598,912,100.00	1,087,900.00	99.9
45	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,875,334,700.00	2,830,842,810.00	44,491,890.00	98.5
46	Засгийн газрын урсгал шилжүүлэг	92,800,000.00	60,283,350.00	32,516,650.00	65.0
47	Засгийн газрын гадаад шилжүүлэг	92,800,000.00	60,283,350.00	32,516,650.00	65.0
48	Бусад урсгал шилжүүлэг	2,782,534,700.00	2,770,559,460.00	11,975,240.00	99.6
49	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,690,418,400.00	2,689,900,000.00	518,400.00	99.9
50	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,483,600.00	31,483,600.00	0.00	100.0
51	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,632,700.00	49,175,860.00	11,456,840.00	81.1
52	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,854,200,000.00	23,949,457,857.70	6,904,742,142.30	77.6
53	Барилга байгууламж	29,138,200,000.00	22,345,101,083.70	6,793,098,916.30	76.7
54	Их засвар	1,536,000,000.00	1,514,556,774.00	21,443,226.00	98.6
55	Тоног төхөөрөмж	180,000,000.00	89,800,000.00	90,200,000.00	49.9
56	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,350,860,400.00	50,635,150,784.39	8,715,709,615.61	85.3
57	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,350,860,400.00	50,635,150,784.39	8,715,709,615.61	85.3
58	Улсын төсвөөс санхүүжих	59,350,860,400.00	50,635,150,784.39	8,715,709,615.61	85.3
59	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	93	93		100.0
60	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
61	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	46	46		100.0
63	Удирдах ажилтан	8	8		100.0
64	Гүйцэтгэх ажилтан	38	38		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,415,317.80
2	УРСГАЛ ЗАРДАЛ	21,415,317.80

3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,728,970.00
4	Хангамж, бараа материалын зардал	398,470.00
5	Тээвэр, шатахуун	398,470.00
6	Томилолт, зочны зардал	4,381,500.00
7	Дотоод албан томилолт	4,381,500.00
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,369,000.00
9	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,369,000.00
10	Бараа үйлчилгээний бусад зардал	580,000.00
11	Бараа үйлчилгээний бусад зардал	580,000.00
12	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,686,347.80
13	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,686,347.80
14	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	13,686,347.80
15	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,415,317.80
16	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,415,317.80
17	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,415,317.80

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ц.Шаравжамц танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр батлагдсан төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх, санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэлд үндэслэн олгож байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-аас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, гэрээт аудитор Ш.Ичинхорлоо нар гүйцэтгэв.

Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/159 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Биеийн тамир спортын улсын хорооны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хөгжлийн чиг хандлага, хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна. Стратеги зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

- Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх;
- Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барих;
- Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлэх;
- Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Биеийн тамир спортын улсын хороо нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Биеийн тамир спортын улсын хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Биеийн тамир спортын улсын хороо нь 2020 онд Засгийн газрын тохируулагч агентлаг, төсвийн төвлөрүүлэн захирагч болсноор нийслэлийн болон 9 дүүрэг, 21 аймгийн Биеийн тамир, спортын газар, хэлтэс, хороод нэгтгэгдэх шийдвэр гарсан байна. Төсвийн төвлөрүүлэн захирагч болсонтой холбоотой 2020 оны 8 дугаар сард Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс байгуулагдан 3 орон тоотой ажилласан ба санхүүгийн үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтуудыг Ковидын цар тахлын үеийн хөл хорионы улмаас хийгдээгүй байна.

Биеийн тамир спортын улсын хорооны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаж “дунд” гэж үнэллээ.

3.4 Материаллаг байдал.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төсвийн шууд захирагчийн 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,105.7 сая төгрөгийн 1.0 хувь буюу 110.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 31,691.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 316.9 сая төгрөгөөр тооцсон.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,039.7 сая төгрөг байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	0.0	0.4	0.4	0.02
Банканд байгаа бэлэн мөнгө	0.0	2,039.3	2,039.3	99.98
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0
Хадгаламж	0.0	0.0	0.0	0.0
Дүн	0.0	2,039.7	2,039.7	100

Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийн 0.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 1,924.0 сая төгрөг төрийн сангийн барьцаа хөрөнгө дансанд, харьяа Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 10.6 сая төгрөг, Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 38.6 сая төгрөг, Техник

спортын төв ТӨААТҮГ-ын 66.1 сая төгрөгийн нийт 115.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл арилжааны банкны дансанд тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 3,403.7 сая төгрөг байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	1.1	1.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	160.5	160.5
Дансны авлага	0.0	119.0	119.0
Байгууллагаас авах авлага	0.0	3,123.1	3,123.1
Хувь хүмүүсээс авах авлага	0.0	0.0	0.0
Дүн	0.0	3,403.7	3,403.7

Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй, 74.7 сая төгрөгийн дараах авлага байна. Тухайлбал:

- Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 4 харилцагчийн 49.3 сая төгрөгийн 4-5 жилийн насжилттай авлага,
- Техник спортын төв ТӨААТҮГ-ын 25.4 сая төгрөгийн авлага нь 5-аас дээш жилийн насжилттай авлага;

Эдгээр нь найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 9,490.0 сая төгрөг байна.

Хүснэгт № 3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.0	9,490.0	9,490.0
Дүн	0.0	9,490.0	9,490.0

Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 9,490.0 сая төгрөгийн үлдэгдэл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор 2021 оны 09 дүгээр сард явагдах “Олон улсын залуучуудын спортын ногоон наадам” арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл бэлтгэх, Спорт цогцолборын барилгын тодорхой хэсгийг санхүүжүүлэх харилцаа болон хамтран ажиллах зохицуулалтыг хангах тухай 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 1/169 тоот гэрээний дагуу Улаанбаатар спорт менежмент ХК-д олгосонтой холбоотой байна.

3.5.4 Бараа материал

Бараа материал дансны үлдэгдэл 1,132.8 сая төгрөг байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	0.0	926.8	926.8
Хангамжийн материал	0.0	206.0	206.0
Дүн	0.0	1,132.8	1,132.8

Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст буюу 2020 оны 12 дугаар сард 119.8 сая төгрөгийн хангамжийн бараа материалыг худалдан авсан байна. Тухайлбал:

- 9.8 сая төгрөгийн шинжилгээний тест,
- 45.4 сая төгрөгийн Шигшээ багийн бэлтгэлд шаардагдах ариутгал, халдваргүйжүүлэлтийн материал, цол зэргийн үнэмлэх, хавтас,
- 6.5 сая төгрөгийн анагаах ухааны эрдэм шинжилгээний материал,
- 58.1 сая төгрөгийн бараа материалыг албаны хэрэгцээнд зориулан тус тус худалдан авсан байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 77,601.9 сая төгрөг байна.

Хүснэгт №5 Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	00.0	77,601.9	77,601.9
Дүн	00.0	77,601.9	77,601.9

Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бүтцийн өөрчлөлтөөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хэрэгжиж байсан төсөл арга хэмжээний хүрээнд дутуу хэрэгжсэн барилга байгууламж болон бусад хөрөнгийг ТӨБЗГ-ын тогтоолоор 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон балансаас балансад холбогдох гэрээ, акт, зураг төсвийн хамт хүлээн авч Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан журманд заасны дагуу бараа материалын бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэсэнтэй холбоотой байна. Тухайлбал:

- 46,797.9 сая төгрөгийн 32 спорт цогцолборын барилга,
- 9,492.3 сая төгрөгийн спорт заалны 23 барилга,
- 1,750.0 сая төгрөгийн 1 Оюуны спортын ордон,
- 1,729.0 сая төгрөгийн 3 спортын талбай,
- 6,347.2 сая төгрөгийн 6 усан бассейн,
- 2,135.0 сая төгрөгийн 2 цэнгэлдэх хүрээлэн,
- 9,333.2 сая төгрөгийн 9 эрх шилжүүлсэн ажлын бараа материал,
- 17.3 сая төгрөгийн 11 тоног төхөөрөмж

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 51,949.2 сая байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	0.0	51,104.8	51,104.8
Биет бус хөрөнгө	0.0	844.4	844.4
Дүн	0.0	51,949.2	51,949.2

Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 46.4 сая, үнэ төлбөргүй авсан 429.4 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжиж ирсэн 57,156.0 сая, бусад үндсэн хөрөнгө 1,999.6 сая төгрөг нийт 59,631.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэн, 7,682.2 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна. Үндсэн хөрөнгийг байгууллагаар нь харуулбал:

- Биеийн тамир, спортын улсын хорооны 2,010.7 сая төгрөг,
- Буянт-Ухаа спорт ордон ТӨААТҮГ-ын 48,388.8 сая төгрөг,
- Техник спортын төв ТӨААТҮГ-ын 793.1 сая төгрөг,
- Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 756.6 сая төгрөг байна

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 1,838.2 сая төгрөг байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Өглөг	0.0	1,786.2	1,786.2	97.2
Урьдчилж орсон орлого	0.0	52.0	52.0	2.8
Нийт дүн	0.0	1,838.2	1,838.2	100

Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат нийт өр төлбөр 1,786.2 сая төгрөг байна. Тухайлбал:

- Биеийн тамир, спортын улсын хорооны 800.4 сая төгрөг,
- Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 487.9 сая төгрөг,
- Техник спортын төв ТӨААТҮГ-ын 348.4 сая төгрөг,
- Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 149.5 сая төгрөгийн тус тус өр төлбөр байна.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 52.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлогын үлдэгдэл байна.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 143,779.2 сая төгрөг байна.

Хүснэгт №8 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан	0.0	32,881.9	32,881.9	22.9
Хуримтлагдсан үр дүн	0.0	82,521.3	82,521.3	57.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.0	28,376.0	28,376.0	19.7

Дүн	0.0	143,779.2	143,779.2	100.0
-----	-----	-----------	-----------	-------

Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны 143,779.2 сая төгрөгийн үлдэгдэл нь Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 48,103.1 сая, Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 641.2 сая, Техник спортын төв ТӨААТҮГ-ын 572.8 сая, Биеийн тамир спортын хороо 94,462.1 сая төгрөгийн хуримтлагдсан үр дүн болон хөрөнгийн дахин үнэлгээнээс тус тус шалтгаалжээ. Үүнд:

- Засгийн газрын оруулсан капиталын 32,881.9 сая төгрөгийн үлдэгдэл нь засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн “Агентлаг байгуулах тухай” 47 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир спортын улсын хороог байгуулж, төсвийн төвлөрүүлэн захирагч болсон.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны 28,376.0 сая төгрөгийн үлдэгдэл нь төвлөрүүлэн захирагчийн харьяа гурван ТӨААТҮГ-ын хөрөнгийн дахин үнэлгээнээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүнгийн 82,521.3 сая төгрөгийн үлдэгдэл нь агентлагт нэгтгэсэн гурван ТӨААТҮГ-ын хуримтлагдсан үр дүн, тайлант хугацааны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус агентлаг нь Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хороо нэртэйгээр төсвийн төвлөрүүлэн захирагч болж өөрчлөгдөн байгуулагдсан.

Биеийн тамир, спортын улсын хороо /Хуучнаар БСШУСЯ-ны харьяа Биеийн тамир, спортын газар, төсвийн шууд захирагч/ нь 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 27,367.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 27,367.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 7,335.1 сая төгрөгийг бууруулж, Олон улсын залуучуудын ногоон наадмын бэлтгэл ажлыг хангах хүрээнд хийгдэх санхүүжилт болох 9,600.0 сая төгрөгийг нэмэгдүүлж нийт 29,632.7 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Олимпын наадам хойшилсонтой холбоотойгоор урсгал үйл ажиллагааны зардлаас 5,457.9 сая төгрөгийг бууруулж, төсвийн төвлөрүүлэн захирагч болсонтой холбоотойгоор хуучнаар БСШУСЯ-ны төвлөрсөн арга хэмжээний зардлаас 4,321.8 сая төгрөг нэмэгдэж нийт 28,496.7 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь оны эхэнд батлагдсан дүнгээс 1,136.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөр 46 арга хэмжээнд зориулан зарцуулахаар 28,496.6 сая төгрөгийг урсгал зардалд, 30,854.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд нийт 59,350.8 сая төгрөгийн төсөв батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны санхүүжилт 28,148.8 сая, хөрөнгийн санхүүжилт 23,962.5 сая төгрөгийг нийт 52,111.3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт урсгал зардлын гүйцэтгэл 50,635.1 сая төгрөг буюу 85.3 хувьтай байгаа нь тус хороо Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 оны нэгдүгээр улирлаас эхлэн зарим зардлыг хязгаарлах, тэвчиж болох зардлыг хойшлуулах, төлөвлөгөөт арга хэмжээг цуцлах зэргээр төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар зохицуулалт хийснээс шалтгаалсан байна. Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 1,476.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21.4 сая төгрөгийг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 0.4 сая, томилолт, зочны зардалд 4.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 2.3 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 0.6 сая нийт 7.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 13.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл нь 2021 оны тайлангийн мэдээлэл тул мэдээлэх хугацаа болоогүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчид 98.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 29.4 сая төгрөгийн 9 зөвлөмжийг тус тус өгсөн ба хэрэгжилт нь 87.5 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	4	98.4	3	98.4	1	0.0	75.0
Зөвлөмж	9	29.4	9	29.4	0	0.0	100.0
Нийт	13	127.8	12	127.8	1	0.0	87.5

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллага 1, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3, нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс, 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ “Зөрчилгүй” санал дүгнэлт, Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 13,623.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 12,526.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2.3 сая төгрөгийн 1 акт тогтоож, 718.0 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 376.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 17 зөвлөмжийг өгсөн. Үүнээс:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 975.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 209.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2.3 сая төгрөгийн 1 акт тогтоож, 644.7 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 119.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг өгсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараахь санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчлийг залруулсан болно. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 6.1 сая төгрөгөөр бараа материалыг илүү, үндсэн хөрөнгийг дутуу тайлагнасан;
- 54.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг урсгал засварын зардлаар тайлагнасан;
- 157.8 сая төгрөгийн их засварын ажлыг дуусаагүй барилгын дансанд бүртгэлгүй урсгал засварын зардлын дансанд бүртгэж тайлант оны үр дүнг илүү тайлагнасан;
- 116.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн капиталжуулах зардлыг дутуу, урсгал засварын зардлыг илүү тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд 10,802.7 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтын санхүүжилтийн орлогыг илүү бүртгэж тайлагнасан;
- Байгууллагын барьцаа хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын дансны 1,180.0 сая төгрөгийн авлага, өглөгийг цэвэр дүнгээр илэрхийлээгүй;

Төвлөрүүлэн захирагчид 73.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 албан шаардлагыг өгсөн болно. Үүнд:

Техник спортын төв ТӨААТҮГ-ын 25.4 сая төгрөгийн он дамжсан авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*; 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэнтэй тус тус нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: . Албан шаардлага өгөх

Биеийн тамир, спортын улсын хорооны тайлант оны 47.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*; 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэнтэй нийцэхгүй,

Шийдвэрлэсэн: . Албан шаардлага өгөх

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэсэнтэй нийцэхгүй байна. Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Биеийн тамир, спортын улсын хороо нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанаас 11 хоногоор хоцроож ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2.-д “төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Төвлөрүүлэн захирагчид 257.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 6 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

"Олон Улсын залуучуудын ногоон наадам" арга хэмжээний санхүүжилтийг 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр бүрэн олгосон ба уг хөтөлбөр арга хэмжээний зарцуулалт, хэрэгжилтийн явцыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үзэж чадаагүй тул хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийгдэх гүйцэтгэлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1. Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал

4.1.1. Илрүүлэлт:

Биеийн тамир, спортын улсын хороо нь тайлант оны хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдэж буй хөрөнгийн худалдан авалт, барилга байгууламжийн угсралтын ажлуудын санхүүжилтийг ажлын гүйцэтгэл болон гэрээнд заасан хуваарьт үндэслэлгүй хөрөнгөөр бүртгэсэн, 12 дугаар сард 5 гүйцэтгэгчдэд гэрээт ажлын эцсийн гүйцэтгэлд үндэслэлгүй 169.7 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Төсвийн тухай хууль хэрэгжихгүй байх,

Гэрээний үүрэг биелэгдэхгүй байх,

Санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх,

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарь, гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож байх

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус засварын ажил нь 2020 онд багтаан дуусахаар гэрээ байгуулсан боловч хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор ажил хойшлогдсон. Дутуу гүйцэтгэлийг санхүүжүүлэхдээ арилжааны банкны гүйцэтгэлийн баталгааг үндэслэн шилжүүлсэн болно.

4.2. Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Олимп дэлхийн аварга тамирчдад сар бүр олгосон урамшууллыг хувь хүний орлогын албан татварын тайланд тусгахдаа "үйл ажиллагааны орлого"-ын төрлөөр тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйл.12.1.1 "урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7.-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын бодитой оршин байх, тохиолдсон байх, үнэн зөв байх зэрэг баталж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.2.2 Эрсдэл:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль хэрэгжихгүй байх;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалт хэрэгжихгүй байх;

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Тамирчдад олгосон урамшууллыг хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу зөв тайлагнаж байх,

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус асуудалд цаашид анхаарал хандуулж зөвлөмжөөр өгсөн шаардлагыг биелүүлж ажиллах болно.

4.3 Урьдчилж гарсан зардалтай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: "Олон Улсын залуучуудын ногоон наадам" арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон ба уг хөтөлбөр арга хэмжээний ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн зарцуулалт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй.

4.3.2 Эрсдэл:

- Төсвийн хөрөнгийн зарцуулалт хяналтгүй, зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх;

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Улаанбаатар спорт менежмент ХК-тай байгуулсан гэрээнд заасны дагуу хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус компанитай "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу гэрээ байгуулаагүй бөгөөд ОУ-ын залуучуудын ногоон наадмын бэлтгэл ажлыг хангах үүднээс татаас хэлбэрээр санхүүжилт өгсөн болно. Иймд Улаанбаатар спорт менежмент компани нь худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахдаа урьдчилгаа төлбөрийн баталгаа болон, техник хяналтын зардлыг суутгаж тооцно.

4.4 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт: Техник спортын төв ТӨААТҮГ нь өөрийн эзэмшлийн гэрчилгээтэй газартай боловч уг газрыг дансанд бүртгэлд тусгаагүй, газрын төлбөр 50.9 сая, алданги 12.6 сая нийт 63.4 сая төгрөгийг тайлант оны зардлаар бүртгэн, өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, 6 дугаар зүйлийн 6.3.2-д *"санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах"* гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын бодитой оршин байх, иж бүрэн байх зэрэг баталж мэдэгдлүүдийг хангахгүй байх,

4.4.2 Эрсдэл:

- Хөрөнгийг дансанд бүртгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байх,

4.4.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын газрыг мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэн, холбогдох данс бүртгэлд тусгах, газрын төлбөртэй холбоотой өглөгийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус асуудалд цаашид анхаарал хандуулж зөвлөмжийг биелүүлж ажиллах болно.

4.5 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

4.5.1 Илрүүлэлт: Бараа үйлчилгээний бусад зардлын данснаас 23.0 сая, Бусдаар гүйцэтгүүлэх төлбөр хураамжийн зардлын данснаас 1.2 сая, нийт 24.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5.-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т *"батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"* гэсэнтэй тус тус нийцэхгүй байна. Санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.5.2 Эрсдэл:

- Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байх;
- Урсгал төсвийн зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн байх;

4.5.3 Өгсөн зөвлөмж:

Зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахдаа холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр гаргуулж ажиллах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах,

4.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус асуудалд цаашид анхаарал хандуулж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

4.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

4.6.1 Илрүүлэлт: Тус байгууллага нь 2020 онд Засгийн газрын тохируулагч агентлаг-төвлөрүүлэн захирагч болсонтой холбоотой өөрийн үйл ажиллагааны онцлог, хууль, журам зааварт нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т *"аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах"* гэсэнтэй нийцэхгүй байна.

4.6.2 Эрсдэл:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж, мөрдөж ажиллаагүй байх;

4.6.3 Өгсөн зөвлөмж:

- Байгууллагын үйл ажиллагаанд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн боловсруулан батлуулж мөрдөж ажиллах.

4.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Манай агентлаг нь Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилээс эхлэн төсвийн төвлөрүүлэн захирагчаар ажиллаж байна. Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ажлын төлөвлөгөөнд Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны онцлогийг шингээсэн НБББББ-ийг боловсруулахаар тусгасан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	Аудитын код:
2021.03.25			САГ-2021/21/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	БИЕИЙН ТАМИР СПОРТЫН УЛСЫН ХОРОО		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Техник спортын төв ТӨААТҮГ нь он дамжсан 25.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	25.4	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Наран-Идэр Д.Алтанчимэг
2	Биеийн тамир, спортын улсын хороо нь тайлант оны 66.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлээс 47.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	47.9	Албан шаардлага өгөх	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн
3	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	0	Албан шаардлага өгөх	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн
4	Биеийн тамир спортын улсын хороо нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанаас 11 хоногоор хоцроосон	0	Албан шаардлага өгөх	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн

5	"Олон Улсын залуучуудын ногоон наадам" арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон ба уг хөтөлбөр арга хэмжээний зарцуулалт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй,	0	Зөвлөмж өгөх	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн
6	Биеийн тамир, спортын улсын хороо нь тайлант оны хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдэж буй хөрөнгийн худалдан авалт, барилга байгууламжийн угсралтын ажлуудын санхүүжилтийг ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтад үндэслэлгүй хөрөнгөөр бүртгэсэн, 12 дугаар сард 5 гүйцэтгэгчдэд гэрээт ажлын эцсийн гүйцэтгэлд үндэслэлгүй 169.7 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн,	169.7	Зөвлөмж өгөх	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн
7	Техник спортын төв ТӨААТҮГ нь өөрийн эзэмшлийн гэрчилгээтэй газартай боловч уг газрыг дансанд бүртгэлд тусгаагүй, газрын төлбөр 50.9 сая, алданги 12.6 сая нийт 63.4 сая төгрөгийг тайлант оны зардлаар бүртгэн, өглөг үүсгэсэн	63.4	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Наран-Идэр Д.Алтанчимэг
8	Бараа үйлчилгээний бусад зардлын данснаас 23.0 сая, Бусдаар гүйцэтгүүлэх төлбөр хураамжийн зардлын данснаас 1.2 сая, нийт 24.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн	24.2	Зөвлөмж өгөх	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн
9	Олимп дэлхийн аварга тамирчдад сар бүр олгосон урамшууллыг хувь хүний орлогын албан татварын тайланд тусгахдаа "үйл ажиллагааны орлого" төрлөөр тайлагнасан	0.0	Зөвлөмж өгөх	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн
10	Биеийн тамир, спортын улсын хороо нь 2020 онд Засгийн газрын тохируулагч	0	Зөвлөмж өгөх	Дарга, Санхүү, хөрөнгө	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн

	агентлаг-төвлөрүүлэн захирагч болсонтой холбоотой өөрийн үйл ажиллагааны онцлог, хууль, журам зааварт нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулаагүй			оруулалтын хэлтсийн дарга	
	Дүн	330.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25 № 491/АД160459

Улаанбаатар хот

САТ-2021/21/СТА-ТТЗ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Биеийн тамир, спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биеийн тамир спортын улсын хороо нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанаас 11 хоногөөр хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т "төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлэх, дахин давтахгүй байх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Signature



Я.САМБУУНЯМ

Б.НАРАНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25 № 492/А0160459

Улаанбаатар хот

САН - 2021/21/СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд "Идеадэвэллопмент ХХК-д төлөх 47,346,035.00 /дөчин долоон сая гурван зуун дөчин зургаан мянга гучин таван/ төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир спортын улсын хорооны захирал Ц.Шаравжамц, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

0010120396

10.10.10.2019 10:20:19 Khorloo Altan Shaardlaga\2021\0325auditin 1-R Газар101.Docx

01091049



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 05

№ 193/А0160459

Улаанбаатар хот

САГ-2021/21/СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Техник спортын төв ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Техник спортын төв ТББ-аас авах 25,409,298.99 /хорин таван сая дөрвөн зуун есөн мянга хоёр зуун ерэн найман/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Техник спортын төв ТӨААТҮГ-ын захирал Б.Наран-Идэр, нягтлан бодогч Д.Алтанчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0325auditin 1-R Газар\100.Docx

001091046



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 494/А0160459

Улаанбаатар хот

САТ - 2021/21/ СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Биеийн тамир, спортын улсын хорооны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, иж бүрэн байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0325auditin 1-R Газар\03.Docx

001091022

[illegible]